

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРЛАЛ

Огноо: 2022 оны 02 дугаар сарын 25-ний өдөр

Тендер шалгаруулалтын дугаар: УУХҮЯ/202211011

Үндэсний геологийн албанаас 2022 онд Улсын төсвийн хөрөнгөөр “1:50000- ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажил”-ын 6 төсөл, ашигт малтмал, эрэл, эрэл-үнэлгээний 3, геологийн сэдэвчилсэн судалгааны 2 төслийг тус тус хэрэгжүүлэх зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах гэж байгаа тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй хуулийн этгээдийг чадварын мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна.

Тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа тендер тул **www.tender.gov.mn** хаягаар мэдээллийг авч, мэдүүлгээ цахим системээр ирүүлнэ.

Энэхүү зөвлөх үйлчилгээ нь дор дурдсан нэр бүхий геологийн судалгааны ажил байна. Үүнд:

Багцын дугаар	Төслийн нэр, байршил, аймаг, сумын нэр, код, (эхлэх, дуусах хугацаа)	Геологийн даалгавар /шийдэх асуудал/
1	2	3
1. 1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажил		
1	Баянзүрх уул-50 Байршил: Булган аймгийн Бүрэгхангай, Орхон, Хишиг-Өндөр, Булган, Бугат, Орхон аймгийн Баян-өндөр сумын нутаг Хавтгай: М-48-112-А, Б, В, Г М-48-124- А, Б, В, Г Код: БЗУ-50 (2022-2025 он)	2729.39 кв.км талбайн хэмжээнд 1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлыг гүйцэтгэж, геологийн тогтоц, ашигт малтмалын тархалтын зүй тогтлыг судалсны үндсэн дээр хэтийн төлөвийн үнэлгээ өгөх.
2	Ханхар уул-50 Булган аймгийн Бүрэгхангай, Орхон, Орхон аймгийн Баян-Өндөр, Жаргалант сумын нутаг Хавтгай: М-48-113-А, Б, В, Г М-48-125- А, Б, В Код: ХрУ-50 (2022-2025 он)	2386.17 кв.км талбайн хэмжээнд 1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлыг гүйцэтгэж геологийн тогтоц, ашигт малтмалын тархалтын зүй тогтлыг судалсны үндсэн дээр хэтийн төлөвийн үнэлгээ өгөх.
3	Үүрэг нуур-50 Байршил: Увс аймгийн Бөхмөрөн, Сагил, Түргэн сумдын нутаг Хавтгай: М-46-50-Г-б, в, г М-46-51-В-а, б, в, г М-46-61-Б-в, г В-а, б, Г-а, б М-46-62-А-б, в, г, Б-а, б, в, г В-а,б Г-а,б М-46-63-А, В-а, б Код: ҮүН-50 (2022-2025 он)	1769.23 кв.км талбайн хэмжээнд 1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлыг гүйцэтгэж геологийн тогтоц, ашигт малтмалын тархалтын зүй тогтлыг судалсны үндсэн дээр хэтийн төлөвийн үнэлгээ өгөх.

4	Мөст уул-50 Байршил: Архангай аймгийн Цахир, Тариат, Хангай сум, Хөвсгөл аймгийн Жаргалант, Завхан аймгийн Их уул сумдын нутаг Хавтгай: М-47-139-А, Б, В, Г М-47-140-А, Б, В, Г L-47-7-А, Б Код: МөУ-50 (2022-2025 он)	3446.97 кв.км талбайн хэмжээнд 1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлыг гүйцэтгэж геологийн тогтоц, ашигт малтмалын тархалтын зүй тогтлыг судалсны үндсэн дээр хэтийн төлөвийн үнэлгээ өгөх.
5	Ямбат уул-50 Байршил: Баян-Хонгор аймгийн Хүрээмарал, Бууцагаан, Бөмбөгөр, Галуут, Жаргалант, Заг сумдын нутаг Хавтгай: L-47-43-В, Г L-47-54-Б, Г L-47-55-А, Б, В, Г L-47-56-А, Б, В Код: ЯаУ-50 (2022-2025 он)	3904.16 кв.км талбайн хэмжээнд 1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлыг гүйцэтгэж геологийн тогтоц, ашигт малтмалын тархалтын зүй тогтлыг судалсны үндсэн дээр хэтийн төлөвийн үнэлгээ өгөх.
6	Овоот шар-50 Байршил: Баян-Өлгий аймгийн Цэнгэл, Улаанхус сумдын нутаг Хавтгай: М-45-93-В-б, в, г, Г М-45-94-Б-в, г, В, Г М-45-104- Б-в, г М-45-105-А, Б М-45-106-А, Б Код: ОШ-50 (2022-2025 он)	2258.66 кв.км талбайн хэмжээнд 1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлыг гүйцэтгэж геологийн тогтоц, ашигт малтмалын тархалтын зүй тогтлыг судалсны үндсэн дээр хэтийн төлөвийн үнэлгээ өгөх.
2. Ашигт малтмалын хэтийн төлөв, эрэл үнэлгээний ажил		
7	Баруун Монголын шатах ашигт малтмалын хэтийн төлөвийн судалгаа Байршил: Баян-Өлгий, Увс, Ховд, Завхан, Говь-Алтай аймгийн зарим хэсэг Код: БМШАМ-2022 (2022-2024 он)	97,244.83 кв.км талбайн хэмжээнд судалгааны талбайд хамаарах бүсүүдийн тектоникийн хөгжлийг орчин үеийн геологийн онолын хөгжлийн хандлагатай уялдуулан тайлбарлах, бүс нутгийн шатах ашигт малтмалын хэтийн төлөвийн үнэлгээ өгөх.
8	Өндөр технологийн түүхий эд-2 Байршил: Сэлэнгэ, Төв, Дундговь, Дорноговь, Хэнтий, Сүхбаатар, Дорнод, Говьсүмбэр, Дархан-Уул аймаг бүтэн, Архангай, Булган, Орхон, Өвөрхангай, Өмнөговь аймгийн нутгийн зарим хэсэг. Код: ӨТТЭ-2 (2022-2024 он)	Монгол орны 104° уртрагаас зүүн талд орших нутаг дэвсгэр хамрагдана. Үүнээс нарийвчилсэн эрэл хийх 20,967.59 кв.км талбай. Үйлдвэрлэлд эрэлт ихтэй өндөр технологийн түүхий эд болдог ашигт малтмалын тархалт, байршлын зүй тогтлыг хүдрийн бүс, дүүрэг, зангилаа, талбайн хэмжээнд тогтоож, орд, илрэл болон сонирхол татах ирээдүй бүхий талбайг нээн илрүүлж түүний хэтийн төлвийн үнэлгээ өгөх.

9	Эрэл-үнэлгээ-4-2022 Байршил: Говь-Алтай аймгийн Баян-Уул, Шарга сум Код: ЭҮ-4-2022 (2021-2024 он)	2,585.21 кв.км талбайн хэмжээнд эрэл-үнэлгээний ажлыг гүйцэтгэн үнэт, өнгөт, хар, ховор, холимог металлын тархалтын зүй тогтлыг тогтоож, нөөц, баялгийн үнэлгээ өгөх. Талбайн хэмжээнд голлох ашигт малтмалын тархалт, байршлын зүй тогтлыг хүдрийн бүс, дүүрэг, зангилаа, талбайн хэмжээнд нарийвчлан тогтоох, ордыг нээн илрүүлэх, гарал үүслийг судлан тогтоож, эрдэс баялгийг үнэлэх, нөөцийг тооцоолох, технологийн загварчлал боловсруулах.
3.Геологийн сэдэвчилсэн судалгааны ажил		
10	Монгол улсын босоо тэнхлэгийн дагуух бүс нутгийн гео-орчины судалгаа Байршил: Монгол Улсын босоо тэнхлэгийн дагуух суурьшал, уул уурхай болон дэд бүтцийн бүтээн байгуулалт явагдаж буй болон хилийн боомт орчмын нутаг Код: Гео-Орчин-2022 (2021-2024 он)	52,659.0 кв.км талбайн хэмжээнд гео-орчны судалгааны ажлыг гүйцэтгэн Монгол Улсын хөгжлийн тулгуур бүс болсон босоо тэнхлэгийг бүсийн хэмжээнд гео-орчинг тодорхойлж, түүний геоэкологийн эрсдэлийн үнэлгээг хийх, дэд бүтэц, тээвэр-холбоо, үйлдвэрлэлийн болон барилга байгууламжийн түүхий эдийн хэрэгцээ, шаардлага, хэтийн төлөвийг үнэлгээ өгөх.
11	Монгол орны алтны металлогений судалгаа Байршил: -Алтны металлогений зураг зохиох ажлыг Монгол орны нийт нутаг дэвсгэрт -Өмнөд Монголын алтны хэтийн төлөвийн судалгааг 45 дугаар өргөргөөс урагш улсын хил хүртэлх нутагт Код: Мета-алт-500 (2022-2025)	372,752.17 кв.км талбай хэмжээнд Монгол улсын өмнөд бүс нутгийн хэмжээнд алтны хүдэржилт, түүний тархалт, байршлын зүй тогтлыг хүдрийн бүс, дүүрэг, зангилаа, талбайн хэмжээнд нарийвчлан тогтоож, алтны хүдэржилтийн гарал үүслийн судлах, эрдэс баялгийг үнэлэх, нөөцийг тооцоолох, хэтийн төлөвийг үнэлэх ажлыг гүйцэтгэх бөгөөд Төв, Зүүн, Баруун Монголын хэмжээнд хийсэн алтны сэдэвчилсэн судалгааны үр дүнгүүдтэй нэгтгэн Монгол орны алтны металлогений зургийг 1:500000-ны масштабтай зохиох, хэтийн төлөвийн үнэлгээ өгөх.

Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14, 15, 16 дугаар зүйлийн шаардлага хангасан байх ба зөвлөх үйлчилгээг гүйцэтгэх чадвартайг нотлох мэдээллийг ирүүлнэ.

Мэдээлэлд дараах зүйлсийг нэмж багтаасан байна.

Үүнд:

- Хуулийн этгээдийн зөвлөх үйлчилгээ үзүүлэхээр сонгосон талбайн нэр, багцын дугаар;
- “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14, 15, 16 дугаар зүйлийн шаардлага хангасан талаар дурдсан албан бичиг;
- Зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлэхэд санал болгож буй мэргэжлийн боловсон хүчний нэрс, анкет /цээж зурагтай/, тэдгээрийн чадвар, туршлагын талаарх мэдээлэл, багийн бүрэлдэхүүн 1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажилд 7-оос доошгүй, ашигт малтмалын хэтийн төлөв блон геологийн сэдэвчилсэн судалгааны ажилд 10-аас доошгүй хүнтэй байхыг нотолсон баримт бичиг;

Зөвлөх үйлчилгээ үзүүлэх нэг баг хэд хэдэн төсөлд санал илгээх боломжтой хэдий ч нэг төслөөр гэрээ байгуулах эрхтэй.

- Инженер техникийн ажилчдын сургууль төгссөн дипломын хуулбарыг нотариатаар баталгаажуулан ирүүлэх;
- Шүүхийн ерөнхий зөвлөлийн төрөлжсөн архивын тодорхойлолт;
- ШШГЕГ-ийн тодорхойлолт;
- Хуулийн этгээдийн тухайн чиглэлээр судалгааны ажил гүйцэтгэсэн туршлагын талаарх мэдээлэл /сүүлийн 5 жилийн байдлаар/;
- Харилцагч банкны хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлгүй талаарх тодорхойлолт;
- Хуулийн этгээдийн 2020, 2021 оны жилийн эцсийн аудитлагсан санхүүгийн тайлан аудитын дүгнэлтийн хамт;

Дараах мэдээллүүдийг ирүүлэх шаардлагагүй бөгөөд Төрийн худалдан авах ажиллагааны/ tender.gov.mn/ цахим системээр дамжуулан шалгах болно. Үүнд:

- Татварын тодорхойлолт; /тендер нээх үеийн байдлаар өр төлбөргүй байх/
- Хуулийн этгээдийн 2020, 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан;
- Нийгмийн даатгалын тодорхойлолт; /тендер нээх үеийн байдлаар өр төлбөргүй байх/
- Ажилтны сүүлийн 3 сарын нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тодорхойлолт;

Сонирхсон этгээд чадварын мэдүүлэгтэй холбоотой нэмэлт мэдээллийг 2022 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 17.00 цаг хүртэл авч болох бөгөөд мэдүүлгээ 2022 оны 03 дугаар сарын 04-ны өдрийн 14.00 цагийн дотор **www.tender.gov.mn** цахим системээр ирүүлнэ үү.

Тендертэй холбоотой тодруулгыг хуульд заасан хугацааны дотор Үндэсний геологийн албаны Үнэлгээний хорооноос албан бичгээр болон 70182011 утсаар хандан авч болно.